ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 09 өдөр Дугаар А/200 Арвайхээр

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" 05 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн "Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Дэлгэрмаа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: С.Солонго (Насан туршийн боловсролын менежер багш)
Гишүүд: М.Дэжидмаа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Ч.Сэрчмаа (Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төвийн дарга)
Ж.Бунджав (Түшиг дөлгөөн өрхийн эрүүл мэндийн төвийн дарга)
Ё.Шүрэнцэцэг (Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвийн дарга)
Багийн Нийгмийн ажилтнууд

2.18-аас дээш насны иргэдийн коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг эрчимжүүлж, вакцинжуулалтын дүн мэдээ, зохион байгуулалттай холбоотой мэдээлэл үр дүнг сумын Онцгой комисст танилцуулахыг ажлын хэсэгт, (Нийгмийн бодлогын мэргэжилтэн Т.Дэлгэрмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:2021/Alban bichig/Zahiramj2021